

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны даргын  
2022 оны 03 сарын 17 өдрийн №2 тоот  
ХОР тушаалын хавсралт



**ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР,  
МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ  
“ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

**Аяны нэр:** “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ”

**Аяны уриа:** ХАЙРАА ХАЙРЛАЯ, ХАНДЛАГАА ӨӨРЧЛӨЕ, ХАМТДАА ҮЛГЭРЛЭЕ.

**Аяны хугацаа:** 2022 оны 03 дугаар сарын 01-ээс 2022 оны 04 дүгээр сарын 01.

**Аяны зорилго:** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.10 дахь хэсэгт заасан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх чиг үүргийнхээ хүрээнд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендэр, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэгийг олон нийтэд хүргэх, эрэгтэй эмэгтэйчүүдэд тулгарч буй жендэрийн асуудлын талаар мэдээлэх, холбогдох төрийн байгууллагуудад хүргэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, асуудлыг шийдвэрлэх эерэг арга замыг нь чиглүүлэх ухуулга нөлөөллийн ажил хийх нь тус аяны зорилго юм.

**Хүрэх үр дүн:**

1. Жендэрийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, өргөжүүлэх.
2. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтдаа нэгдэж ажиллаж амьдрах эерэг хандлагыг хөхүүлэн дэмжих.
3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, Гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих нийгмийн эерэг сэтгэлгээг бий болгох.
4. Жендэрийн асуудлаар гэр бүлийн оролцоог нэмэгдүүлж, зан үйлийг өөрчлөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлөх.
5. Төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг зохих түвшинд өргөжүүлэх.
6. Олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

**Үндэслэл:** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.2 дэх хэсэгт “жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ хэмээн заасан байдаг. Энэ хүрээнд энэ жилийн Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тус тусад нь бус хамтад нь нэгтгэж, аян зохион байгуулж байгаагаараа илүү онцлогтой болно. Өнгөрсөн хугацаанд зөвхөн эмэгтэйчүүдийн эсвэл эрэгтэйчүүдийн тухай чиглэсэн олон талт арга хэмжээ зохион байгуулж байсан бол энэ жилийн хувьд “ХАЙРАА ХАЙРЛАЯ, ХАНДЛАГАА ӨӨРЧЛӨЕ, ХАМТДАА ҮЛГЭРЛЭЕ” гэсэн уриан дор соён гэгээрэл, нөлөөллийн ажил хийж хэрэгжүүлэхээр зорьж байна. Учир нь жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгаан нь

эрэгтэй, эмэгтэй хүнд ялгаагүй бий. Хохирогчид нь өөрийгөө хамгаалах чадваргүй хүүхэд, эмэгтэйчүүд ихэвчлэн байдаг нь судалгаагаар нотлогддог бөгөөд энэ чиглэлд зориулж, сургалт, нөлөөллийн ажлыг чамгүй хийж хэрэгжүүлсэн туршлага бидэнд байдаг. Эрэгтэйчүүдэд чиглэсэн аяныг эмэгтэйчүүд бидэнд хамааралгүй сэдэв хэмээн анхаарахгүй үлдэх, эмэгтэйчүүдэд чиглэсэн аян зохион байгуулахаар эрэгтэйчүүд нь бидэнд хамааралгүй сэдэв хэмээн орхих зэргээр хамрах хүрээ хязгаарлагдаж байсан. Энэхүү туршлага дээрээ үндэслэн Жендэрийн Үндэсний Хороо ЖСХ, ГБХ-ийн суурь шалтгаантай тэмцэе, гэр бүлийн гишүүн бүр жендэрийн мэдрэмжтэй харилцан хүндэтгэлтэй байя, гэр бүл, хүний эрхийн асуудал эрэгтэй, эмэгтэй хүн бүрийн асуудал юм гэдэг агуулгаар тус аяныг зохион байгуулж байна.

**Дэмжигч байгууллага:** НҮБ-ын Хүн Амын Сан

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Жендэрийн Үндэсний Хорооны Ажлын алба

**Хамтран ажиллах байгууллага:**

ЖҮХ-ны Салбар зөвлөл, Салбар хороод  
Хүний эрх, жендэрийн чиглэлээр үйл ажиллагаа  
явуулдаг ТББ, Иргэний нийгмийн байгууллагууд  
Олон улсын байгууллага  
Хэвлэл мэдээллийн байгууллагууд

-oo000ooo-

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны даргын  
2022 оны 02 сарын 17 өдрийн АТ тоот  
тушаалын хавсралт



**ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР,  
МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ  
“ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Хугацаа (олон нийтэд түгээх)
1	Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизтэй хамтран “Хайрлаарай” нэвтрүүлгийн уран бүтээлчдээр “Хүндлэл дүүрэн гэр бүл” сэдвийн хүрээнд танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх.	2022.03.08 2022.03.18 -ны орой нийт 2 удаа цацагдана.
2	“Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудлаар” үндэсний хэмжээний цахим хэлэлцүүлэг зохион байгуулах. 2-3 цагийн хэлэлцүүлэг байна.	2022.03.04-ны өдөр 1 удаа зохион байгуулагдана.
3	Ийгл телевизтэй хамтран “Эрэгтэйчүүдийн манлайлал, тулгамдаж буй тодорхой асуудал” телевизийн хэлэлцүүлэг зохион байгуулах.	2022.03.17-ны орой 1 удаа цацагдана.
4	Нийгмийн сүлжээнд нөлөөллийн мэдээлэл түгээх. Эрэгтэй, эмэгтэйчүүдэд зэрэг зан үйл, хандлагыг сурталчилж, уриалах.  4 төрлийн постер. 2 төрлийн шторк. 1 төрлийн лого бүтээх.	2022.03.01-2022.04.01 хооронд цацагдана.
5	Нийгмийн сүлжээний <b>MGL радио подкаст, Ийгл Радио 91.1-Eagle.mn Uyanga’s podcast</b> гэх мэт дээрх сошиал 2 сувгаар дамжуулан подкаст хийлгэж цацах. Улмаар “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” Хайраа хайрлая, хандлагаа өөрчлөө, хамтдаа үлгэрлээ цахим чалленжэд олон нийтийг уриална.	2022.03.05 2022.03.17- нд тус тус цацагдана.
6	ЖҮХ-ны Салбар зөвлөл, Салбар хороо бүр чалленжид нэгдэж, аяны хүрээг тэлж, идэвхжүүлэх ажил зохион байгуулах тухай чиглэл хүргүүлж, хамтран ажиллах.	2022.02.17-ны өдөр албан тоот хүргүүлэх. 2022.02.25-ны өдөр цахим хуралдаан зохион байгуулах.
7	Аяны тухай мэдээ, мэдээллээр хангах, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах.	2022.02.15-2022.04.01